

“ШИЖИРГОУЛД” ХХК

**Төв аймгийн Байгаль орчин
аялал жуучлалын газарт**

Монгол улс, Баянгол дүүрэг 6-р
хороо, 10-р хороолол, 19А-3 тоот.
Утас: 976-88107520

2022.11.01 № 22/25

танай _____-ны № _____ -т

Хүсэлт гаргах нь

Манай компани нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-002392 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Хошуу уул”-ын алтны шороон ордын С-5, С-7 блокуудыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Төв аймгийн Байгаль орчин аялал жуучлалын газарт хүргүүлж байна.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлантай танилцаж дүгнэлт гаргаж өгнө үү.

Хүндэтгэсэн:

ЗАХИРАЛ



/Ж. УЯНГА/

Батлав:

БОАЖЯ, ХБОБНУГ-ын дарга:

/ А. ЭНХБАТ/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“ШИЖИРГОУЛД” ХХК-ийн захирал:



/ Ж.УЯНГА /

**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“ХОШУУ УУЛ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН
С-5, С-7 БЛОКУУДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/Тусгай зөвшөөрлийн дугаар MV-002392/

/Аж ахуй нэгжийн регистрийн дугаар 5282586/

Хянасан:

БОАЖЯ, ХБОБНУГ-ын

ахлах мэргэжилтэн:

/ Ц. ЖАРГАЛНЭМЭХ/

Боловруулсан:

“ШИЖИРГОУЛД” ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн

/ Г. НАРАНГОО/

Агуулга

1.	ОРШИЛ	3
1.	ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
1.1.	Төслийн нэр:.....	4
2.	ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ.....	6
2.1.	Хүчин чадал:.....	6
2.2.	Уурхайн ажиллах горим:.....	6
2.3.	Тоног төхөөрөмжийн сонголт:.....	6
2.4.	Ордын нөөцийн тооцоо	6
2.5.	Ашиглалтын үеийн хаягдал ба бохирдол.....	6
2.6.	Уулын ажлын төлөвлөлт	6
2.7.	Уурхайн хотхон.....	9
2.8.	Цахилгаан хангамж.....	9
2.9.	Усан хангамж, усны хэрэглээ.....	9
2.10.	Хог хаягдлын менежмент	11
3.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	13
4.	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
5.	ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
6.	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
7.	ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	19
8.	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	19
9.	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
10.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 24	
11.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ.....	26
12.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	27
13.	2021 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН НИЙТ ЗАРДАЛ.....	29
	АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ	30

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
Хүснэгт №2. Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэмшиж буй талбайн захын цэгүүдийн солбицол.	4
Хүснэгт №3. Ил уурхайн ажлын горим.....	6
Хүснэгт №4. Уурхайн хүрэн дэх нөөц, /Сорьц-870.0/.....	6
Хүснэгт №5. Уулын ажлын календарь төлөвлөгөө	7
Хүснэгт №6. Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл	7
Хүснэгт №7. Шимт хөрс хуулалт	8
Хүснэгт №8. Төслийн нийт ажилчдын тоо	8
Хүснэгт №9. Барилга, байгууламжийн мэдээлэл	8
Хүснэгт №10. Хотхоны цэвэр усны хэрэглээ	10
Хүснэгт №11. Технологийн усны хэрэглээ.....	11
Хүснэгт №12. Ил уурхайн зам усалгааны усны хэрэглээ	11
Хүснэгт №13. Төслийн нийт цэвэр усны хэрэглээ	11
Хүснэгт №14. Хог хаягдлын тооцоо.....	11
Хүснэгт №15. Усны норм.....	12
Хүснэгт №16. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	13
Хүснэгт №17. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	14
Хүснэгт №18. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	17
Хүснэгт №19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	19
Хүснэгт №20. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	21
Хүснэгт №21. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	24
Хүснэгт №22. Олон нийтэд тайлагнах төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь	26
Хүснэгт №23. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	27
Хүснэгт №24. 2021 оны БОМТ-ний нийт зардал.....	28

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №1. Төслийн талбайн байршлын зураг.....	5
Зураг №2. Худгийн байршлын зураг.....	10
Зураг №3. Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулсан байдал.....	15
Зураг №4. Хог хаягдлын цэг, хашаалсан байдал.....	18
Зураг №5. Уурхай дахь галын булангийн фото зураг.....	20
Зураг №6. Хувцас хэрэгсэл хангамж	21
Зураг №7. Замын тэмдэгжүүлэлт.....	22
Зураг №8. Ажилчдын эмчийн үзлэгт орж байгаа байдал.....	24
Зураг №9. Хөрсний дээж авч байгаа үеийн зураг.....	25
Зураг №10. Шинжилгээ хийж байгаа үеийн зураг.....	27

1. ОРШИЛ

“Ноён тохойн трейд” ХХК нь “Шижир гоулд” ХХК-тай MV-002392 тоот тусгай зөвшөөрлийн талбайд ашиглалт болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулахаар гэрээ байгуулсан болно. “Хошуу уул”-ын алтны шороон ордын төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялагийг ашиглах үйл ажиллагааг зохистойгоор шийдвэрлэх арга зам, түүнд шаардагдах зардлыг хамруулан тусгасан баримт бичгийг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө гэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

“Шижиргоулд” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Төслийн нэр:

“Шижиргоулд” ХХК нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших MV-002392 тоот Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай “Хошуу уул” алтны шороон ордын С-5 блокыг ил аргаар ашиглах.

1.2. Төслийн байршил:

“Хошуу уул”-ын алтны шороон орд нь Төв аймгийн Сэргэлэн сумын төвөөс зүүн урагш 18 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 80 км, Налайхын уурхайгаас 35 км, Улаанбаатар-Сайншандын төмөр замын 7-р зөрлөг, Цагаанхяргас 6 км-т зайд байрлана.

1.3. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших “Хошуу уул” нэртэй 201.83 га талбай бүхий ашигт малтмалын MV-002392 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдөр “Хүдэр-Эрдэнэ” ХХК-д олгосон бөгөөд 2008 онд “Алмаз групп” ХХК шилжүүлэн авч, улмаар 2012 оны 07 дугаар сарын 31-ний өдөр “Шижиргоулд” ХХК нь “Алмаз групп” ХХК-аас шилжүүлэн авсан байна.


Хүснэгт №1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд	
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Шижиргоулд” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	9011182042
3	Уурхайн нэр	“Хошуу уул”-ын алтны шороон ордын С-5, С-7 блокуудыг ил аргаар ашиглах төсөл
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг
5		Сум/Дүүрэг
6	Ашигт малтмалын төрөл	алт
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-002392
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот
10		Сум/Дүүрэг
11		Баг/Хороо
12		Гудамж/Байр
13		Хаяг
14		тоот
21	Удирдлагын мэдээлэл	“Шижир гоулд” ХХК
22		Утас
23		“Ноён тохой трейд” ХХК
24		Гар утас

Хүснэгт №2. Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэмшиж буй талбайн захын цэгүүдийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градиус	Минут	Секунт	Градиус	Минут	Секунт
1	107	12	44.44	47	29	7.73
2	107	12	44.44	47	29	21.73
3	107	13	19.43	47	29	21.73
4	107	13	19.43	47	29	38.72
5	107	13	42.43	47	29	38.72
6	107	14	42.43	47	29	53.73
7	107	14	7.44	47	29	53.73
8	107	14	7.34	47	30	9.77
9	107	14	21.34	47	30	9.77
10	107	14	21.35	47	30	25.77
11	107	13	54.34	47	30	25.77
12	107	13	54.34	47	30	9.77

13	107	13	24.34	47	30	9.77
14	107	13	24.43	47	29	54.73
15	107	13	0.43	47	29	54.73
16	107	13	0.43	47	29	39.72
17	107	12	31.43	47	29	39.72
18	107	12	31.43	47	29	23.72
19	107	12	11.44	47	29	23.74
20	107	12	11.42	47	29	7.74
21	107	12	44.44	47	29	7.73



Зураг №1. Төслийн талбайн байршлын зураг

2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ

2.1. ХҮЧИН ЧАДАЛ:

“Ил уурхай нь 2022 онд 2 дугаар улиралд 12.83 мян.м³, 3 дугаар улиралд 38.82 мян.м³ элс олборлохоор төлөвлөсөн.

2.2. УУРХАЙН АЖИЛЛАХ ГОРИМ:

Уурхай нь 6-р сараас 9-р сарын хооронд жилд 85 хоног ажиллана.

Хүснэгт №3. Ил уурхайн ажлын горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	11
2	Хоног дахь ээлжийн тоо	ээлж/хон	1
3	Жилд ажиллах хоногийн тоо	хоног/жил	85
4	Жилд ажиллах ээлжийн тоо	ээлж/жил	85
5	Жилийн ажлын цагийн хэмжээ	цаг/жил	850
6	Цаг ашиглалт		92
7	Жилд ажиллах бодит цаг		782

2.3. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СОНГОЛТ:

Тус уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдэд Doosan-SD-300 маркийн дугуйт ачигч 2 ширхэг Liebherr 734 маркийн бульдозер 1ш, байна.

2.4. ОРДЫН НӨӨЦИЙН ТООЦОО

Ил уурхайн хүрээ хязгаарт өртөх блокууд болон ашиглалтын нөөцийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт №4. Уурхайн хүрээн дэх нөөц, /Сорьц-870.0/

Блокийн дугаар, Нөөцийн зэрэг	Блокийн талбай	Хөрсний зузаан	Элсний зузаан	Хөрсний эзлэхүүн	Элсний эзлэхүүн	Дундаж агуулга	Хими цэвэр
Х.нэгж	/мян.м ² /	/м/	/м/	/мян.м ³ /	/мян.м ³ /	гр/м ³	/кг/
5-С	18.4	0.7	1.2	12.94	22.18	0.89	19.64
7-С	14.8	0.7	1.2	10.39	17.81	1.49	26.56
Нийт (С)	33.3	0.7	1.2	23.3	39.9	1.55	46.20

2.5. АШИГЛАЛТЫН ҮЕИЙН ХАЯГДАЛ БА БОХИРДОЛ

Элсний давхарга дотор чулуулгийн үенцэргүй, нөөцийг хаягдалгүй бүрэн олборлох үүднээс үйлдвэрлэлийн нөөцөд элсний давхаргын таазнаас, улнаас, хажуугаас нэмэгдэх хоосон чулуулаг элсний үеийг бохирдуулна гэж үзсэн байна. Хамгаалалтын үеийн бүх чулуулаг бохирдуулагч болох бөгөөд ордын хэмжээнд бохирдлын хувь 17.31% буюу бохирдуулагч чулуулгийн хэмжээ 7.62 мян.м³ байна. Бохирдлын хэмжээ үнэмлэхүйгээр 17.31% нөхцөлд алттай элсийг хаягдалгүйгээр олборлох боломжтойгоор ТЭЗҮ-ийг боловсруулжээ.

2.6. ҮҮСМЭЛ ОРДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ

Тус орд нь III бүлгийн орд тул хайгуулын ажлаар тогтоогдсон геологийн боломжтой (С) зэргийн нөөцөд тулгуурлан ордыг ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулсан бөгөөд уурхайн хил хязгаар дотор орших бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай үйлдвэрлэлийн нөөцийг уул уурхайн сайдын 2015 оны 9-р сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу боломжтой (С) зэргийн нөөцийг магадласан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын үйлдвэрлэлийн нөөц нь нийт магадласан В' зэргээр 51.66 мян.м³ элс буюу хими цэврээр 50.50 кг алт болж байна. /Шлихээр 58.05 кг/

2.7. УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Хуулах хөрсийг бүгдийг нь шимт хөрсний овоолгод хураахаар тооцсон ба уурхайн жил бүрийн хөрс хуулалт, элс олборлолтын хэмжээг тогтмол барих, ашиглалт явуулах дарааллыг тогтоох замаар төлөвлөлтийг шийдэж төслийг боловсруулав.

Хүснэгт №5. Уулын ажлын календарь төлөвлөгөө

Ашиглалтын улирал	Хөрс хуулалт, мян.м ³	Элс олборлолт, мян.м ³	Бохирдол		Үйлдвэрлэлийн нөөц, мян.м ³	Хаягдал бохирдол тооцсоны дараах хөрсний хэмжээ, мян.м ³	Хөрс хуулалтын коэффициент, м ³ /м ³
			%	мян.м ³			
II улирал	8.31	19.49	17.31	1.89	12.83	5.48	0.43
III улирал	10.06	23.59	17.31	5.73	38.82	16.57	0.43
IV улирал	1.56	3.85	17.31				
Бүгд	19.9	46.93	17.31	6.94	46.93	19.9	0.43

2.7.1. УУРХАЙН НЭЭЛТ, АШИГЛАЛТЫН СИСТЕМ

Уурхай нь өмнө С-5, С-7 блок дээр ашиглалт явуулж байсан ба С-7 блокоос эхлэн олборлолт явуулах бөгөөд замын ерөнхий схем нь уурхайн зүүн хойд ханыг даган өгсөж +1565-аас 1575 м түвшин хүрнэ.

2.7.2. АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ: “Хошуу уул”-ын алтны шороон ордын хөрсний зузаан нь таазны бохирдол хасаж тооцсоноор дунджаар 0.4 м байна. Иймд шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар хуулан овоолно.

Ордын элс нь хэвтээ ойролцоогоор 1⁰ уналттай, нөөцийн блокуудын өргөн жигд үргэлжилдэг тул ашиглалт явуулсан талбайд дотоод овоолго хийж ашигладаг ба ордын ашиглалтанд тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын системийг ашиглаж байна.

Хүснэгт №6. Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын технологи	1. Хөрс хуулалт	1.1. Түрэх 1.2. Овоолох
	2. Олборлолт	2.1. Ухаж ачих 2.2. Тээвэрлэх 2.3. Овоолох (агуулахад хураах)

Уурхайн тээвэр

Уурхайн олборлолтонд ашиглах автосамосвалууд нь ил уурхайгаас олборлох элсийг уурхайн гол замаар тээвэрлэж элсний агуулахад (түр овоолго) хураана.

Дотоод тээвэрт БНХАУ-д үйлдвэрлэсэн Howo-ZZ3257 маркийн 14м³ багтаамжтай автосамосвал ажиллана.

2.7.3. УУРХАЙН ДОТООД БОЛОН ГАДАРГУУГИЙН ЗАМ:

Автозамын техникийн нөхцөл нь замын норм дүрмийн дагуу хоёр урсгалтай, замын зорчих хэсгийн өргөн тооцоогоор 6.6 м байна. Сонгосон өргөн нь 10 м, замын налуу 8⁰ байна.

Ил уурхайн технологийн процессууд

Ил уурхайн үйл ажиллагаа нь шимт хөрсийг түрж хуулах-овоолох, элсийг ухаж ачих, тээвэрлэн түр овоолгод овоолох гэсэн үндсэн процессоор явагдана.

2.7.4. ШИМТ ХӨРС ХУУЛАХ

Шимт хөрсийг Liebherr 764 маркийн бульдозероор түрж шимт хөрсний овоолгод овоолно. Шимт хөрсний овоолгыг 35⁰ градусын налууугайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулна. Шимт хөрсийг уурхайн талбайгаас 0.2 метр зузаантайгаар хуулна. Уурхайн талбайгаас 7.34 мян.м³ шимт хөрс хуулж овоолно. Шимт хөрс хуулах ажлын зардлыг хөрс хуулалтын зардалд оруулан тооцсон

Хүснэгт №7. Шимт хөрс хуулалт

Ашиглалтын жилүүд	Шимт хөрс хуулалт, мян.м ³	
	Уурхайн талбай	Нийт
Жилд	7.34	7.34
Нийт	7.34	7.34

2.7.5. ОВООЛГО

Ил уурхайгаас хуулах шимт хөрсийг уурхайн 1 талд шимт хөрсний овоолгод хураана. Хөрсийг гадаад, дотоод овоолгод, эфель, гаалийг уурхайн ашиглагдсан орон зайд дотоод овоолгод овоолно. Ил уурхайд Liebherr 734 маркийн бульдозер ашиглана.

2.7.6. УГААН БАЯЖУУЛАХ ХЭСЭГ

Угаан ангилал төхөөрөмжийн хүрдэн шүүрийн доод ангиллын бүтээгдэхүүн шлюзийн баяжуулалт руу орно. Шлюзны баяжмалыг ээлжиндээ 1 удаа /10цаг тутамд/ авах ба баяжмал хадгалах саванд цуглуулна. Цуглуулсан баяжмалыг 2 мм хэмжээтэй нүхтэй шигшүүрээр шигшинэ. Шигшүүрийн -2 мм бүхэллэгтэй хэсгийг баяжуулах ширээнд өгөх ба +2 мм бүхэллэгтэй хэсгийг гар тэвш буюу лоткигоор гүйцээн баяжуулна. Баяжуулах ширээнээс шлихийн алт, завсрын бүтээгдэхүүн, хаягдал гэсэн 3 бүтээгдэхүүн гарна. Баяжуулах ширээний баяжмалыг гар тэвш буюу лоткигоор гүйцээн баяжуулна.

2.7.7. БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЛТЫН ТООЦОО

“Хошуу уул”-ын алтны шороон ордод 2021 онд 9.0 мян.м³ элс олборлон 3086.4 гр шлихийн, 2707.95 гр алт олборлон борлуулсан.

2.7.8. АЖИЛЧДЫН БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төслийн хүчин чадлыг бүрэн ашиглахад хангалттай тооны ажилчдыг тусгаж өгсөн бөгөөд уулын хэсгийн ажлын горим 1 ээлжээр ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна, харин угаан баяжуулах хэсгийн ажилчид хоногт 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 9 цагаар ажиллана.

Хүснэгт №8. Төслийн нийт ажилчдын тоо

№	Хэсэг нэгж	2022 он
1	Уулын хэсэг	9
2	Угаан баяжуулах хэсэг	10
3	Засвар механикийн хэсэг	6
4	Захиргаа, аж ахуй, үйлчилгээний хэсэг	6
5	Нийт	31

2.8. БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

“Шижиргоулд” ХХК нь тусгай зөвшөөрлийн талбайд уурхайн захиргаа, засвар үйлчилгээний төв зэрэг барилга байгууламжуудыг байрлуулсан.

Орд ашиглалтын хугацаа бага тул зөөж тээвэрлэхэд хялбар шийдлийг сонгосон болно. Дараах хүснэгтэд “Шижиргоулд” ХХК-ийн барилга байгууламжууд, бүтэц эдлэл, хэмжээг тусгалаа.

Хүснэгт №9. Барилга, байгууламжийн мэдээлэл

№	Барилгын нэр	Х.нэгж	Хэмжээ	Тайлбар
Хотхон				

1	Уурхайн удирдлагын байр	м ²	14.4	20 тн контейнер-хаус 1 ш
2	Ажилчдын сууц	м ²	142	40 тн контейнер-хаус 4 ш
3	Цайны газар	м ²	28.4	20 тн контейнер-хаус 1 ш
4	Халуун ус болон угаалга	м ²	30	1 ш сендвичин байр
Ил уурхай				
5	Засварын газар, сэлбэгийн агуулах	м ²	28.4	20 тн контейнер 1 ш
6	Засварын талбай	м ²	100	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна
7	Түлшний ёмкост	тн	10	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна

2.9. УУРХАЙН ХОТХОН

Ажилчдын сууц: Уурхайн тосгон тусгай зөвшөөрлийн талбайд 142 м² талбайг хамарна. Ажилчдын хотхоныг нийт 28 хүн, нөөц тооцооноор 30 хүн зэрэг байрлах хүчин чадалтай, шаардлагатай тавилга, эд хогшлоор тоноглогдсон байна. Ажилчдын сууцыг 40 тонны контейнерийг засч тохижуулан хүн амьдрах тав тухыг бүрдүүлсэн байна.

Хоолны газар: Цайны газар нь ажилчдын сууцны нэгэн адил 20 тонны контейнерыг засаж тохижуулан хүн тав тухтай хооллох орчныг бүрдүүлсэн байна. 1 контейнер-хауст 1 удаадаа 15-20 хүн зэрэг хооллох бөгөөд 1 хүнд дунджаар 2.4 м² талбай ноогдож байна.

Холбооны байгууламж: Уурхайн орчимд үүрэн телефоны Мобиком корпорацийн сүлжээ барьдаг. Уурхайн экскаватор, автосамосвал зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдана. Холбоо дохиололтой холбоотой зардлыг ашиглалтын хэсэг тус бүрт тусгаж өгсөн.

Түлшний агуулах: Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний агуулах нь 10 хоногийн нөөц буюу 10000 литр түлш хадгалах багтаамжтай байна. Эдгээр нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга зайлуулагч хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж өгнө.

Засвар механикийн барилга байгууламж: Уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг үйлдвэрийн талбайд байрлах засварын талбайд хийж гүйцэтгэнэ. Засварын талбайд дугуй засвар, гагнуур, компрессорын станц зэргийг эхний ээлжинд байгуулна.


2.10. ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Цахилгаан хангамжийн эх үүсвэр: “Хошуу уул”-ын уурхай нь ТЭХ-ний системийн Налайх 7-р зөрлөгийн 10 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамаас хуурай салгуураар салаалан, 0.4 кВ-ийн хүчдэлтэй 250 кВа-ын суурилагдсан хүчин чадалтай хаалттай дэд станц угсарч ЦЭХ-ээр хангаж байна.

2.11. УСАН ХАНГАМЖ, УСНЫ ХЭРЭГЛЭЭ

“Хошуу уул”-ын алтны шороон ордын усны хэрэглээг уурхайд гаргасан 1ш гүний худгаас хангана. Худгийн ундарга 8 л/с байна. Гүний худгийн солбилцол нь 107⁰14"01', 47⁰30"01' байна.

Уурхайн усны хэрэглээг БОНХАЖ-ын сайдын тушаалаар батлагдсан 2015.07.30-ны өдрийн А/301 тоот “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормоор тооцсон.



Зураг №2. Худгийн байрилын зураг

2.11.1. АЖИЛЧДЫН ХОТХОН, УНД АХУЙН УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Уурхайн хотхоны унд-ахуйн усны хэрэглээнд нийт 111.6 м³ ус зарцуулна.

Хүснэгт №10. Хотхоны цэвэр усны хэрэглээ

Ажиллах жил	Ажилчдын тоо	Жилд ажиллах хугацаа	Нэг хүний хоногийн усны хэрэглээ	Хоногт шаардлагатай усны хэрэглээ	Жилийн усны хэрэглээ
2022 он	хүн	хоног	л	м ³ /хон	м ³ /жил
	31	120	30	0.93	111.6

Тус суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүд нь Усны тухай хуулийн 30 дугаар зүйл, Ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлага буюу 30.1.4 дэх заалт, Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуучлалын сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн А/156 дугаар тушаалаар баталсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Төв аймгийн Сэргэлэн сумын 3-р багийн нутагт MV002392 лицензийн талбай N47¹29⁰85.8, 107¹13⁰30.8 бүхий LXLC -50 мм –ийн голчтой ус авах цэгт усны тоолуур байршуулсан.

2.11.2. ТЕХНОЛОГИЙН УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Тунаах нуурын усны эзлэхүүн ойролцоогоор 68.660 м³, усны гүн 2 м орчим байна. Тунаах нуур нь уурхайн урд хэсэгт (хамгийн ойр зай 5 м), өмнөх онуудад ашиглаж байсан ба энэ нь дахин ашиглах бүрэн боломжтой тул уг төсөлд тус нуурыг ашиглахаар төлөвлөсөн.

Тунаах нуураас усыг 150 мм-ийн диаметртэй, 200 м урттай HDPE хоолойгоор дамжуулан баяжуулах төхөөрөмжид хүргэх ба үүнд Д-320-50Б маркийн 300 м³/цаг, 2BV2-70 маркийн 80 м³/цаг хүчин чадал бүхий насосыг тус тус ашиглана.

Унд ахуйн зориулалттай усыг 5 тн ёмкость бүхий автомашинаар худгаас зөөвөрлөнө. Зам талбайн усалгаанд тусгайлан тоногдсон автоцистерн (5 тн)-ийг ашиглана.

Хүснэгт №11. Технологийн усны хэрэглээ

Ажиллах жил	Угаах элсний хэмжээ	1 м ³ элс угаахад шаардагдах ус	Шаардагдах усны хэмжээ	Цэвэр усны хэмжээ,	Эргэлтийн усны хэмжээ,
				30%	70%
	(м ³)	м ³	м ³ /жил	м ³ /жил	м ³ /жил
2022 он	38,820	4	155,280.00	46,584.00	108,696.00

Баяжуулах төхөөрөмж ашиглалтын хугацаанд 9000 м³ элсийг угаах ба ашиглалтын хугацаанд 10.800 м³ ус ашиглана.

2.11.3. ЗАМ ТАЛБАЙН УСАЛГАА

Зам талбайн болон нөхөн сэргээлтийн усалгаанд ашиглах усыг тунаах нуур болон худгийн уснаас хангах ба уурхайн замын нийт урт II-р улирал 954 м урт өргөн 8 м, III-р улирал 390 м урт өргөн нь 8 м байна. Усалгааг 7 хоногт 3 удаа, 4-9 сарын хугацаанд нийт 36 удаа усална гэж тооцсон.

Хүснэгт №12. Ил уурхайн зам усалгааны усны хэрэглээ

№	Усалгааны төрөл	Норм (л/м ²)	Талбай (м ²)	Хоногт хэрэглэх усны хэмжээ л /хо	Жилд услах хоног	Жилд, м ³ ус
1	Зам талбай	2	3120	6,240	24	149760

Ил уурхайн зам усалгааны усны хэрэглээнд нийт 149.7 м³ ус хэрэглэхээр байна.

2.11.4. ТӨСЛИЙН НИЙТ УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Үйлдвэрийн хэрэгцээнд худгаас ашиглалтын хугацаанд нийт 47,091.81 м³ ус хэрэглэхээр байна. Ордыг ашиглахад шаардлагатай усны ундрогын хэмжээ 1.2 л/с байна. Гүний худгийн ундарга 8 л/с бөгөөд уурхайн усны хэрэгцээг хангаж байна.

Хүснэгт №13. Төслийн нийт цэвэр усны хэрэглээ

Ажиллах хугацаа	Усны хэрэглээ /м ³ /				Шаардлагатай усны эх үүсвэр /л/с/			
	Ил уурхайн зам	Угаан баяжуулах	Хотхон	Нийт	Ил уурхайн зам	Угаан баяжуулах	Хотхон	Нийт
2022 он	149.76	46,584.00	358.05	47,091.81	0.016	5.03	0.05	5.10

2.12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хатуу хог хаягдлын дийлэнх хувийг сав баглаа боодол эзэлнэ. Төслийн үйл ажиллагаанаас доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гарна.

- ✓ Хүнсний зүйлсийн сав, баглаа боодол,
- ✓ Бие засах газрын хаягдал
- ✓ Ундааны сав, лааз
- ✓ Хоолны үлдэгдэл зэрэг тус төсөлд хоногт ихдээ 31 хүнээр тооцсон.

Хүснэгт №14. Хог хаягдлын тооцоо

Нийт ажиллах хоног	Ахуйн хог хаягдал, кг	Хүний тоо	Нийт, тн/жил
107	0.3	31	995.1 тн

Дээрх хүснэгтээс алтны шороон ордод жилд ойролцоогоор 995.1 тн ахуйн хог хаягдал гарахаар байна. Төв аймгийн Сэргэлэн сумын засаг даргатай гэрээ байгуулж, тогтмол хугацаанд тээвэрлүүлдэг байна.

2.12.1. ШИНГЭН ХОГ, ХАЯГДАЛ

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтын дагуу гүний худгаас хангах бол 150 л/хоног/хүнээр тооцсон болно. Үүнд:

Хүснэгт №15. Усны норм

Нийт ажиллах хоног	Хоногт хэрэглэх ус, л/хоног/хүн	Нийт хүний тоо	Нийт, тн/жил	Шингэн хаягдал /30%/, тн/жил	Шингэн хаягдал /70%/, тн/жил
107	150	31	497.55	149.26 тн	348.28 тн

Дээрх хүснэгтээс харахад ахуйн хэрэглээнд жилд хамгийн ихдээ ойролцоогоор 497.55 л ус шаардлагатай байна. Үүний 70% буюу 348.28 тн ус шингэн хаягдал болон гарах тооцоотой байна. Нийт усны хэрэгцээг 100% “Уурхайн гүний худгаас авч” ашиглахаар төсөлд тусгагдсан болно.

2.12.2. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

Аюултай хог хаягдал гэдэгт техникийн ажилласан тос, масло, тээврийн хэрэгсэлийн хаягдал резин дугуй, хаягдал шил, баттерэй, аккумулятор гэх мэт орно.

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт №16. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлт	Нийт зардал, төг / 2022 он/
АГААР			
1	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол хийх, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Тоосжилт үүсэхээс сэргийлэх үүднээс замын усалгааг байнга хийж байгаа	Дотоод төлөвлөлтөөр
4	Тээврийн хэрэгсэлийн хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол байлгах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Машин механизмуудын үзлэгийг тогтмол хийдэг. Техникийн үзлэгт хамрагдсан.	291,200
ДУУ ЧИМЭЭ			
1	Дуу шуугианы хэмжилт, агаарын чийгшил, агаар хөрсний температур зэргийг хэмжилт (олон үйлдэлдэлт хэмжигч NO9AQ багажаар) хийх.	NO9AQ багажаар хэмжилт хийсэн	Дотоод төлөвлөлтөөр
УС			
1	Унд ахуйн ус болон зам усалгааны усны дээж авч лабораториор шинжлүүлэх	Үерийн уснаас хамгаалах, хамгаалалтын далан шуудуу татсан	Зардал осол эрсдэлийн төлөвлөгөөний зардалд орсон
2	Зуны улиралд аадар борооны үед үер болох нөхцөлтэй тул уурхай, овоолго зам талбай усанд автахаас сэргийлж үерийн уснаас хамгаалах, хамгаалалтын далан шуудуу барих арга хэмжээ авах	ШТМ тослох материалын алдагдалаас урьдчилан сэргийлж хяналт тавьж ажиллаж байна.	Дотоод төлөвлөлтөөр
3	ШТМ хөрсөнд асгарахаас сэргийлэх, асгарсан тохиолдолд тухай бүрт саармагжуулах арга хэмжээ авах	Төв амгийн Сэргэлэн сумын засаг даргын 02/227 тоот мэдэгдлийн дагуу тоолуурын заалтанд үндэслэн тайланд хавсаргав.	645.000
4	Ус ашигласны төлбөрийг цаг тухай бүрт төлөх	Төлбөр төлсөн баримтыг хавсаргав.	2,000,000
ХӨРСӨН БҮРХЭВЧ			
1	Тээврийн хэрэгсэлийг маршрутын бус замаар явуулахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах, сайжруулах.	Уурхайн зам талбайд тэмдэгжүүлэлт тавьж машин механизмуудыг тогтмол замаар явуулж, зам талбай барьж байгуулсан	-
2	Хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах	Өнгөн хөрсийг хуулан шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан	Дотоод төлөвлөлтөөр
УРГАМАЛ			
1	Тээврийн хэрэгслийг маршрутын дагуу явуулах, хүний хөл хөдөлгөөнөөр ургамлан нөмрөг талхагдахаас сэргийлэх	Тээврийн хэрэгслийг маршрутын дагуу замаар явуулж байгаа	-
АМЬТАН			
1	Хууль бус агнуур хийхгүй байхад анхаарч, хяналт тавих	Хууль бус агнуур хийхгүй байхад анхаарч ажиллаж байна.	-
НИЙТ			2,936,200

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Шижир гоулд” ХХК нь Ашигт малтмал, газрын тосны газар, Геологи уул уурхайн кадастрын хэлтсээс олгосон ашигт малтмалын орд газрыг ашиглах MV-0002392 тоот хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй. Уул уухайн олборлох үйлдвэрлэлийг 2022 оны батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу MV-002392 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн С-5, С-7 блокуудад олборлолт явуулж 46.9 мян.м³ хүдэр олборлохоор төлөвлөсөн байна.

Хүснэгт №17. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Биелэлт	Нийт зардал, төг / 2022 он/
1	Уулын ажил болон уурхайн бусад үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд зогсохгүй байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах нөхөн сэргээлтийн ажлуудыг цогц байдлаар хийх юм.	Техникийн нөхөн сэргээлтийг 9 га орон нутгийн байгаль орчинтой хамтарч тэрбум мод тарих төслийн хүрээнд тод тарьсан зургийг хавсаргав.	3,500,000



Зураг №3. Нөхөн сэргээлт хийх талбайн газар тэгшилэлт



Зураг №4. Мод тарьсан талбайн



Зураг №5. Тэрбум мод төслийн хүрээнд тарьсан модны зураглал



Зураг №6. Мод тарихаар бэлтгэж байгаа газрын зураглал

5. БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Баруун, баруун уртын хөндийн дунд хэсэг” алтны үүсмэл шороон ордыг ашиглах явцад 2022 онд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гадаад овоолгоор хийж гүйцэтгэнэ.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, төг
1	Биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд орон нутгийн байгаль орчны газар болон иргэдтэй хамтран ажиллах	Орон нутгийн байгаль орчны газар болон иргэдтэй зөвлөлдөн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан	2,000,000.0
Нийт			2,000,000.0



Зураг №7. Газар тэгшилэлтийн зураглал

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх газрыг Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас санал авсны үндсэн дээр эвдэрсэн газрыг техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр санал, шийдвэрт хүрсэн.

Хүснэгт №18. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Биелэлт	Нийт зардал, төг / 2022 он/
1	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутагтай хамтарч ажиллах,	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг 2 га талбайд хийж гүйцэтгэсэн дүйцүүлэн	3,500,000

дүйцүүлэн хамгаалах ажил хийх санал орон нутгаас авах, хэрэгжүүлэх.	хамгаалалт хийсэн газрын координатыг тайланд хавсаргав	
---	--	--



Зураг №8. Тэрбум мод тарих төслийн хүрээнд тарьсан мэднэ зураглал



Зураг №9. Тэрбум мод тарих төслийн хүрээнд тарьсан млдны зураглал

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ашиглалтын талбайд малчин өрх, айл суурьшдаггүй. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө хийгдэхгүй болно.

8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. “Шижиргоулд” ХХК биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенцийг мөрдлөг болгон уурхай орчмын дурсгалт газрууд, өнгөрсөн үеийн хүн төрөлхтний түүхийн дурсгалууд, биет бус соёлын өв болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын олон янз байдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, хамгаалах чиглэлээр ажиллах ба энэ талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн БОМТ-д тусган хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Шижиргоулд” ХХК нь Төв аймгийн Сэргэлэн сумын засаг даргатай хог хаягдлыг тухай бүрт гэрээний дагуу тээвэрлэхээр гэрээ хийсэн. Уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлыг хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хүснэгт №19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах, арга хэмжээ	Биелэлт	Нийт зардал, төг / 2022 он/
1	Уурхайд ахуйн хатуу хог хаягдал хаях зориулалтын хогийн савыг сайжруулах	Уурхайн гадна талбайд зориулалтын хогийн сав байрлуулсан	-

2	Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хог хаягдлын цэгийг хашаалах, сайжруулах арга хэмжээ авах	Хог хаягдлыг байгаль орчинд тараахгүй байх үүднээс зориулалтын хашаалсан хогийн сав байршуулсан	-
3	Хог хаягдлыг орон нутгаас заасан хогийн төвлөрсөн цэгт цаг тухай бүрт тээвэрлүүлэх, орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулан үргэлжлүүлэн ажиллах	Орон нутгийн ТҮК-тай гэрээ байгуулан хог хаягдлыг ачуулсан. Төлбөрийн баримт хавсаргав.	360,000
4	Хог хаягдлыг ангилан ялган цуглуулж, хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах	ТҮК-тай гэрээ байгуулсан гэрээг хавсаргав.	-
5	Ажиллагсдын бие засах газар, бохирын цооногт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	Ажилчдын бие засах газар болон хогийн цэг орчмыг ариутгал тогтмол хийлгэж байгаа	-
6	Аюултай хог хаягдал хадгалах сав байрлуулах, стандартын шаардлага хангасан хаяг шошготой байх	Хогийн савны гадна талд шошго таних тэмдэг байршуулсан	
Нийт			360,000





Зураг №10. Хог хаягдлын цэг, хашаалсан байдал

10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдэлээс үүсэх сөрөг нөлөөлөл:

- Болзошгүй аюул, осол, аваар гарах,
- Техник технологийн шугам сүлжээний гэмтэл,
- Галын гэнэтийн аюул үүсэх,
- Байгалийн гамшиг үүсэх,
- Ажилчдын эрүүл мэнд муудах.

Хүснэгт №20. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Биелэлт	Нийт зардал, төг / 2022 он/
1	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянаж ажиллах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хяналт тавьсан	ХАБЭА-н зардлаар
2	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Ажилдад галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан ажилчдын байр зэрэг зохих газруудад гал унтраах хэрэгслүүдийг байрлуулж, самбар тэмдэг тэмдэглэгээг хадсан	
3	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах		
4	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж шаардлагатай газруудад байрлуулах		

5	Ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.	Дотоод төлөвлөлтөөр
6	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр бүрэн хангах (өлмийний хамгаалалттай түрийтэй гутал, хамгаалалтын нүдний шил, дуулга, тоосны маск, ажлын бээлий гэх мэт)	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлээр бүрэн хангаж ажиллаж байна.	ХАБЭА-н зардлаар
7	Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, шинж тэмдэг илэрсэн бол нэн даруй ойр буй эмнэлэгт мэдэгдэх арга хэмжээ авах.	Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх шаардлагатай тохиолдолд эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлж байгаа	Дотоод төлөвлөлтөөр
8	УОКомиссоос гаргасан шийдвэрийг дагаж мөрдөх Коронавируст халдвараас сэргийлэх хамгаалалтын амны хаалт маск зүүх, бээлий өмсөх, спиртийн агууламжтай гар ариутгагч хэрэглэх гэх мэт.	УОКомиссоос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Коронавируст халдвараас сэргийлэх хамгаалалтын амны хаалт маск зүүх, бээлий өмсөх, спиртийн агууламжтай гар ариутгагчаар ханган ажиллаж байгаа	



Зураг №11. Уурхай дахь галын булангийн фото зураг



Зураг №12. Хувцас хэрэгсэл хангамж



Зураг №13. Замын тэмдэгжүүлэлт

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Шижиргоулд” ХХК нь жил бүрийн БОМТ-г хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө тайлагнаж ажиллана. Үйл ажиллагаандаа техник, технологийн сахилга бат чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга болон хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны мэргэжилтэнгүүд хариуцан ажиллана.

Хүснэгт №21. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	Нийт зардал, төг / 2022 он/
1	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөж ажилладаг	Дотоод төлөвлөлтөөр

2	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан	ХАБЭА-н зардлаар
3	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хамтран ажиллах	Орон нутгийн саналыг харгалзан үзэж хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилласан.	Дотоод төлөвлөлтөөр
4	Уурхайд байгаль орчны аудит хийлгэх	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹ зүйлд заасны дагуу байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэн гэсэн заалтын дагуу 2021 он нь төслийн эхний жил байсан бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажиллаагүйгээс 2022 онд үргэлжлүүлэн ажиллах учир аудитыг 2022 ондоо багтааж хийлгүүлнэ.	-
Нийт			



Зураг №14. Ажилчдын эмчийн үзлэгт орж байгаа байдал

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

Хүснэгт №22. Олон нийтэд тайлагнах төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах газар
1	Төв аймаг, Сэргэлэн сум	Уулзалт, санал асуулга, тайлан хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	Дотоод төлөвлөлтөөр	Төв аймаг, Сэргэлэн сум
2	Төв аймгийн БОАЖГазар, БОАЖЯ-ны ХБОБНУГ-т.	Тайлан хэлбэрээр, албан бичиг	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийн тайлан болон тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	Дотоод төлөвлөлтөөр	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийн тайлан болон тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Дотоод төлөвлөлтөөр	Засаг даргын тамгын газар

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Хошуу уул”-ын алтны шороон ордын С-7 блокуудыг ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ. Тухайн төслийг хэрэгжүүлэх явцад ус, хөрс, агаарт үүсэх бохирдол, байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг бүрт орох аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц дээж авах болон хэмжилт хийх цэгийн байршил, шинжилгээгээр тодорхойлох үзүүлэлтүүд шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах хэлбэр зэргийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нарийвчлан тусгана. “Шижиргоулд” ХХК нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн.

Хүснэгт №23. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Хяналтын цэгийн байршил	Биелэлт	Нийт зардал, төг / 2022 он/
Хөрс				
1	Хөрсний химийн болон физик үндсэн шинж чанар (Ялзмаг, урвалын орчин, карбонат, нитрат, фосфор, кали, давсжилт, чулуужилт, механик бүрэлдэхүүн, эзлэхүүн жин зэрэг үзүүлэлтүүд)	-Ил уурхай, -Хөрсний овоолго, -Дотоод тээврийн зам, -Кемп орчмоос	Уурхайн карьерын гадна талбайгаас дээж авч “ШУА-ийн Газарзүй-Геозкологийн хүрээлэнд хийлгэсэн. Шинжилгээний хариуг тайланд хавсаргасан	106,000
2	-Хөрсний хүнд металл. кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	-Ил уурхай, -Кемп орчмоос	Хөрсний хүнд металлын шинжилгээг ШУА-ийн Газарзүй- Геозкологийн хүрээлэнд хийлгэсэн. Шинжилгээний хариуг тайланд хавсаргасан	
Ус				
1	Усны ерөнхий химийн шинжилгээ, рН, TDS (нийт ууссан давс), нийт хатуулаг (CaCO ₃), ууссан хүчилтөрөгч, БХХ, ХХХ, Са, Mg, Na, К, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ -ны агууламж, амт, үнэр, өнгө	Унд ахуйн усыг хангаж буй гүний худгаас 4ш дээж өгсөн	Ахуйн хэрэглээний уснаас ерөнхий шинжилгээ авсан. Ундны уснаас дээж авч ШУА, Газарзүй-Геозкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний хариуг тайланд хавсаргасан	180.000
Нийт				286,000



Зураг №15. Хөрсний дээж авч байгаа үеийн зураг



Зураг №16. Шинжилгээ хийж байгаа үеийн зураг

**14. 2021 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН НИЙТ ЗАРДАЛ**

Хүснэгт №24. 2022 оны БОМТ-ний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал / төгрөг / 2022 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,936,200
2	Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	3,500,000
3	Биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2,000,000
3	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3,500,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	360,000
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	286,000
11	БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-
Нийт		12,582,200

ДҮГНЭЛТ

“Шижиргоулд” ХХК -ийн Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших “Хошуу уул”-ын алтны шороон ордын С-5 блокоос олборлолт, нөхөн сэргээлт хийсэн ажлын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг “Шижиргоулд” ХХК-тай БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тоот БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

“Шижиргоулд” ХХК нь 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, цаг тухай бүрт шаардлагатай арга хэмжээнүүдийг авч сөрөг нөлөөллийг бууруулж ажилласан.

“Шижиргоулд” ХХК нь 9 га талбайд Техникийн нөхөн сэргээлт 2 га талбайд дүйцүүлэн хамгаалалтын хүрээнд нөхөн сэргээлт хийж нутгийн удирдлагуудад танилцуулсан.

Мөн тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилтыг бууруулж тухай бүрт усалгаа хийж, ажилчдад хөдөлмөр хамгааллын арга хэмжээний зааварчилгаа өгч, агаар, ус, хөрсний шинжилгээнүүдийг тухай бүрт өгч, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших “Хошуу уул” ордыг С-5, С-7 блокуудыг ил аргаар ашиглах төслийн 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө
2. Төв аймгийн Сэргэлэн сумын “Хошуу уул” алтны шороон ордын БОННУ тайлан, 2021 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын журам, аргачлал /гарын авлага/ УБ 2014 он
4. БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам.



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2009.01.22

/Бүртгэсэн он, сар, өдөр/

9011182042

/Улсын бүртгэлийн дугаар/

5282586

/Регистрийн дугаар/

Шижиргоулд

Хязгаарлагдмал хариуцлагатай компан

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм

/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Тогтоол

/Шийдвэрийн нэр/

01

/дугаар/

2009.01.19

он, сар, өдөр

511000

/код/

Гадаад худалдаа

/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

/код/

/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй

хугацаа

2


/Гишүүдийн тоо/

1,000.0

/Өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/

Баянгол, 6-р хороо, 10-р хороолол, 19А - 3, утас1:99042536, утас2:99118326, факс:

/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/




Харилцах банкны бүртгэл:

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан, тэмдэг
Капитал банк	Төгрөгийн	2000010476	Б. Аевирмэд

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Огноо	Бүртгэсэн Ажилтан, тэмдэг
1.	Дүрмийн шинэчилсэн найруулагыг бүртгэв.	2012.06.26	Э. Эрдэнэбилэг 7126





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 2392А

Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар
зүйлийг үндэслэн

Төв аймаг /хот/-ийн

Сэргэлэн сум /дүүрэг/-ын

Хошуу уулын урхайн досд хэсэг нэртэй газарт орших

201 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд

заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн 9011074044 тоот гэрчилгээтэй

...Хүдэр-Эрдэнэ... ДНЖ -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 30 жилийн

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.



АШИГТМАЛЫН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ

Ц. ГАНХУЯГ

2006 оны 12 сарын 15 өдөр

Улаанбаатар хот



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-002392

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Хөдөлгөөний код	Хөдөлгөөний тайлбар	Гарын үсэг, огноо, тамга
000-CI	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 127 тоот тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлыг WGS-84 тогтолцоонд албан ёсоор хөрвүүлж талбайн хэмжээг дахин тооцсон.	
013-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 11 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2010.06.19 – 2011.06.19 хүртэл	2010.06.14
014-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 12 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2011.06.19 – 2012.06.19 хүртэл	2011-06-19
015-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 13 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2012.06.19 – 2013.06.19 хүртэл	2012-06-13
016-TF	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 9011182042 тоот улсын бүртгэлийн дугаартай Шижиргоулд ХХК-д шилжүүлэхГУУКХ-ийн даргын 2012.07.30-ний 499 тоот шийдвэр	2012-07-31



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-002392

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Хөдөлгөөний код	Хөдөлгөөний тайлбар	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, гарын үсэг, огноо, тамга
000-CI	<ul style="list-style-type: none"> Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 127 тоот тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлыг WGS-84 тогтолцоонд албан ёсоор хөрвүүлж талбайн хэмжээг дахин тооцсон. 	201.83 Га	0 Га	1 107° 12' 44.44" 47° 29' 7.73" 2 107° 12' 11.42" 47° 29' 7.74" 3 107° 12' 11.44" 47° 29' 23.74" 4 107° 12' 31.43" 47° 29' 23.72" 5 107° 12' 31.43" 47° 29' 39.72" 6 107° 13' 0.43" 47° 29' 39.72" 7 107° 13' 0.43" 47° 29' 54.73" 8 107° 13' 24.43" 47° 29' 54.73" 9 107° 13' 24.34" 47° 30' 9.77" 10 107° 13' 54.34" 47° 30' 9.77" 11 107° 13' 54.34" 47° 30' 25.77" 12 107° 14' 21.35" 47° 30' 25.77" 13 107° 14' 21.33" 47° 30' 9.77" 14 107° 14' 7.34" 47° 30' 9.77" 15 107° 14' 7.44" 47° 29' 53.73" 16 107° 13' 42.43" 47° 29' 53.73" 17 107° 13' 42.43" 47° 29' 38.72" 18 107° 13' 19.43" 47° 29' 38.72" 19 107° 13' 19.43" 47° 29' 21.73" 20 107° 12' 44.44" 47° 29' 21.73" <div style="text-align: right; border: 1px solid red; padding: 2px;"> ГЕОЛОГИ, УУЛ УРХАЙН ХАВААРЧЛАЛЫН ХАЛДЭГ УХА02 2010-04-01 Э. Заяабат </div>
016-TF	<ul style="list-style-type: none"> Тусгай зөвшөөрлийг 9011182042 тоот улсын бүртгэлийн дугаартай Шижиргоулд ХХК-д шилжүүлэх Шийдвэрийн огноо: 2012.07.30 	201.83 Га	0 Га	1 107° 12' 44.44" 47° 29' 7.73" 2 107° 12' 11.42" 47° 29' 7.74" 3 107° 12' 11.44" 47° 29' 23.74" 4 107° 12' 31.43" 47° 29' 23.72" 5 107° 12' 31.43" 47° 29' 39.72" 6 107° 13' 0.43" 47° 29' 39.72" 7 107° 13' 0.43" 47° 29' 54.73" 8 107° 13' 24.43" 47° 29' 54.73" 9 107° 13' 24.34" 47° 30' 9.77" 10 107° 13' 54.34" 47° 30' 9.77" 11 107° 13' 54.34" 47° 30' 25.77" 12 107° 14' 21.35" 47° 30' 25.77" 13 107° 14' 21.33" 47° 30' 9.77" 14 107° 14' 7.34" 47° 30' 9.77" 15 107° 14' 7.44" 47° 29' 53.73" 16 107° 13' 42.43" 47° 29' 53.73" 17 107° 13' 42.43" 47° 29' 38.72" 18 107° 13' 19.43" 47° 29' 38.72" 19 107° 13' 19.43" 47° 29' 21.73" 20 107° 12' 44.44" 47° 29' 21.73" <div style="text-align: right; border: 1px solid red; padding: 2px;"> ГЕОЛОГИ, УУЛ УРХАЙН ХАВААРЧЛАЛЫН ХАЛДЭГ УХА02 2012-07-31 Э. Заяабат </div>

**АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ . . . 2392 А . . . ТООТ ЛИЦЕНЗИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ**
(гэрчилгээгүй бол хүчингүй)

Лицензээр олгогдсон талбайн хэмжээ болон лицензийн эзэмшилд орсон өөрчлөлт

д/д	Лицензэд орох өөрчлөлтийн үндэслэл	Өргөдлийн бүртгэлийн дугаар	Хасагдах талбайн хэмжээ (га-аар)	Үлдсэн талбайн хэмжээ (га-аар)
1.	Анх олгосон	3099А	-	201 2000-06-19 0214
2.	Лицензийн хоёр дах жилийн төлбөрөө төлөв.			201 2001-06-14
3.	ГУУКА-ны даргын 2002 оны 304 тоот шийдвэрийн дагуу лицензийг 21/707 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй Худалдаа хөгжлийн банкинд барьцаалуулан хадгалуулав.	123А	-	201 2002-05-02
4.	Лицензийн гурав дахь жилийн төлбөрөө төлөв.			201 2002-06-03
5.	Лицензийн дөрөв дахь жилийн төлбөрөө төлөв.			201 2003-06-05 УХА0214
6.	Лицензийн тав дахь жилийн төлбөрөө төлөв.			201 2004-05-31
7.	Лицензийн 6 дахь жилийн төлбөрөө төлөв.			201 2005-06-02
8.	Лицензийн 7 дахь жилийн төлбөрөө төлөв.			201 2006-06-09 УХА0214
9.	Тусгай зөвшөөрлийн 8 дахь жилийн төлбөрөө төлөв			201 2007-06-12
10	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг улсын бүртгэлийн 9011110143 гэрчилгээтэй „Алмаз групп,, ХХК-д шилжүүлснийг ГУУКГ-ын даргын 2008 оны 684 тоот шийдвэрээр бүртгэв.	T6339А		201 2008-05-07

Тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгэв. ш-1292
АМГТХОГ-ын ГУУКА-ны Бүртгэл, тооцооны хэлтсийн дарга Ч. Алтанбаатар 2008 оны 12 сарын 15 өдөр

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ . . . 2392.А . . . ТООТ ЛИЦЕНЗИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ
(гэрчилгээгүй бол хүчингүй)



Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлын өөрчлөлтүүд

д/д	Солбицлууд өөрчлөгдөх үндэслэл	Хүчин төгөлдөр солбицлууд
8.	Лицензийн 7 дахь жилийн төлбөрөө төлөв.	<p style="text-align: center;">Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 2006-06-09</p> <p style="text-align: center;">Тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн үргэв. м - 7892 АМГТХЭГ-ын ГУУКА-ны Бүртгэл, тооцосны хэлтсийн Дарга Ч. Алтанбаатар Алтанбаатар 2006 оны 12 сарын 15 өдөр</p>
9.	Тусгай зөвшөөрлийн 8 дахь жилийн төлбөрөө төлөв	<p style="text-align: center;">Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 2007-06-12</p>
10	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг улсын бүртгэлийн 9011110143 гэрчилгээтэй „Алмаз групп,, ХХК-д шилжүүлснийг ГУУКИ-ын даргын 2008 оны 684 тоот шийдвэрээр бүртгэв.	<p style="text-align: center;">Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 2008-05-07</p>
11.	Тусгай зөвшөөрлийн 9 дахь жилийн төлбөрөө төлөв.	<p style="text-align: center;">Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 2008-06-17</p>
12.	Тусгай зөвшөөрлийн 10 дахь жилийн төлбөрөө төлөв.	<p style="text-align: center;">Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 2009-06-09</p>

2392A








АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ТООТ
 ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ
 (тусгай зөвшөөрөлгүй бол хүчингүй)

Тусгай зөвшөөрлөөр талбайн хэмжээ болон тусгай зөвшөөрлийн эзэмшилд орсон өөрчлөлт

д/д	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Өргөдлийн бүртгэлийн дугаар	Хасагдах талбайн хэмжээ (га-аар)	Үлдсэн талбайн хэмжээ (га-аар)
11.	Тусгай зөвшөөрлийн 9 дахь жилийн төлбөрөө төлөв.			
12.	Тусгай зөвшөөрлийн 10 дахь жилийн төлбөрөө төлөв.			

**АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ . . . 2392.А . . . ТООТ ЛИЦЕНЗИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ
(гэрчилгээгүй бол хүчингүй)**


Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлын өөрчлөлтүүд

д/д	Солбицлууд өөрчлөгдөх үндэслэл	Хүчин төгөлдөр солбицлууд
1.	Талбайн анхны солбицлууд	<p>1. 107° 12' 10" 47° 29' 06" 11. 107° 14' 20" 47° 30' 24"</p> <p>2. 107° 12' 10" 47° 29' 22" 12. 107° 14' 20" 47° 30' 08"</p> <p>3. 107° 12' 30" 47° 29' 22" 13. 107° 14' 06" 47° 30' 08"</p> <p>4. 107° 12' 30" 47° 29' 38" 14. 107° 14' 06" 47° 29' 52"</p> <p>5. 107° 12' 59" 47° 29' 38" 15. 107° 13' 41" 47° 29' 52"</p> <p>6. 107° 12' 59" 47° 29' 53" 16. 107° 13' 41" 47° 29' 37"</p> <p>7. 107° 13' 23" 47° 29' 53" 17. 107° 13' 18" 47° 29' 37"</p> <p>8. 107° 13' 23" 47° 30' 08" 18. 107° 13' 18" 47° 29' 20"</p> <p>9. 107° 13' 53" 47° 30' 08" 19. 107° 12' 43" 47° 29' 20"</p> <p>10. 107° 13' 53" 47° 30' 24" 20. 107° 12' 43" 47° 29' 06"</p> <p>2000-06-19  Т. Дэлгэрмаа</p>
2.	Лицензийн хоёр дах жилийн төлбөрөө төлөв.	<p>Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр.</p> <p align="center"> 2001-06-14</p>
3.	ГУУКА-ны даргын 2002 оны 304 тоот шийдвэрийн дагуу лицензийг 21/707 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй Худалдаа хөгжлийн банкинд барьцаалуулан хадгалуулав.	<p>Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр.</p> <p align="center"> 2002-05-02</p>
4.	Лицензийн гурав дахь жилийн төлбөрөө төлөв.	<p>Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр.</p> <p align="center"> 2002-06-03</p>
5.	Лицензийн дөрөв дахь жилийн төлбөрөө төлөв.	<p>Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр.</p> <p align="center"> 2003-06-05</p>
6.	Лицензийн 7 дав дахь жилийн төлбөрөө төлөв.	<p>Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр</p> <p align="center"> 2004-05-31</p>
7.	Лицензийн 6 дахь жилийн төлбөрөө төлөв.	<p>Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр</p> <p align="center"> 2005-06-02</p>



УУЛ УУРХАЙН КАДАСТРЫН ЗУРАГ

Шилжүүлсэн талбай



БАЙРШИЛ ЗҮЙ

- | | | | |
|--|--------------|--|------------------------|
| | Аймаг | | Нэг зэвсгэлт төмөр зам |
| | Сум | | Хоёр зэвсгэлт |
| | Нийслэл | | Планкын (1:100 000) |
| | Аймагийн төв | | Шаргалзгүй нуур |
| | Сумын төв | | Шаргалзг нуур |

ӨРГӨДЛИЙН ТАЛБАЙ

- Шилжүүлсэн талбай





Компаний нэр: ШИНЖИР ГОУЛА ХХК
 Захирал: Ж. УЯНГА
 Гарын үсэг: У.Мал
 Талбайн нэр: ХОШ УУ УУЛЫН ДООД ХЭСЭГ.
 Планшет #: L-48-23



Байршил:	Д/д	Хот, аймаг	Сум, дүүрэг
	1	Төв: 201.83 Га	Сэргэлэн: 201.83 Га

Солбицлууд:

Д/д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	107	12	44.44	47	29	7.73
2	107	12	11.42	47	29	7.74
3	107	12	11.44	47	29	23.74
4	107	12	31.43	47	29	23.72
5	107	12	31.43	47	29	39.72
6	107	13	0.43	47	29	39.72
7	107	13	0.43	47	29	54.73
8	107	13	24.43	47	29	54.73
9	107	13	24.34	47	30	9.77
10	107	13	54.34	47	30	9.77
11	107	13	54.34	47	30	25.77
12	107	14	21.35	47	30	25.77
13	107	14	21.33	47	30	9.77
14	107	14	7.34	47	30	9.77
15	107	14	7.44	47	29	53.73
16	107	13	42.43	47	29	53.73
17	107	13	42.43	47	29	38.72
18	107	13	19.43	47	29	38.72
19	107	13	19.43	47	29	21.73
20	107	12	44.44	47	29	21.73

Зөвшөөрөв:		ГУУКХ-ийн дарга М.Энхтулга
		ГУУКХ-ийн зураг зүйн мэргэжилтэн М. Энхтулга



“ШИЖИРГОУЛД” ХХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР


15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3, Утас: 26-36-28, Факс: 31-03-70
E-mail: info@mram.gov.mn

2012.07.31 № 6-4400
танай _____-ны № _____-т

Шийдвэрийн дагуу мэдэгдэл
хүргүүлэх тухай

“Алмазгрупп” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дахь Хошуу уулын уурхайн доод хэсэг нэртэй 201.83 гектар талбай бүхий MV-002392 тоот тусгай зөвшөөрлийг шилжүүлэх өргөдлийг TR-008256 дугаарт бүртгэн хянаж үзээд Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т заасныг үндэслэн Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2012 оны 7 -дугаар (дүгээр) сарын 30 -ны (ний) өдрийн 499 -дугаар (дүгээр) шийдвэрээр ашигт малтмалын хайгуулын MV-002392 тоот тусгай зөвшөөрлийг (тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн булангийн цэгүүд хэвээр) танай компанид шилжүүлснийг бүртгэж, тусгай зөвшөөрлийн хавсралтад тэмдэглэгээ хийснийг мэдэгдье.

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН КАДАСТРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



М.ЭНХТУЛГА

10 07407


ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН
КАДАСТРЫН ЛАВЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

Кадастрын лавлагаа

Лавлагааны мэдээлэл



Таны лавлагаа авах хүсэлт мэдээллийн санд бүртгэгдлээ. Хүсэлтийг хянан Ашиг малтмал, газрын тосны газарт цахим байдлаар хүргэгдэнэ.

Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-002392
Талбайн нэр	Хошуу уулын уурхайн доод хэсэг
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, га	201.83
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Шижиргоулд
Аймаг, сум, сав газрын нэр	Төв аймаг Сэргэлэн сум, Умард говийн гүвээт-Халхын дундад тал голын сав газар
Хуулиар хориглосон бүстэй давхцалтай эсэх	давхцалгүй
Давхацсан талаарх мэдээлэл	








ТАНИХ ТЭМДЭГ





Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

-  Ашиглалтын
-  Хайгуулын

Засаг захиргааны хил

-  Улсын хил
-  Аймгийн хил
-  Сумын хил
-  Аймгийн төв
-  Сумын төв


Тусгай хамгаалалттай газар нутаг

-  Дархан цаазат газар
-  Байгалийн цогцолборт газар
-  Байгалийн нөөц газар
-  Дурсгалт газар



Хамгаалалтын бүсүүд

-  Гол мөрний урсац бүрэлдэх эх
-  Ойн сан бүхий газар


Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

-  Онцгой хамгаалалтын бүс
-  Энгийн хамгаалалтын бүс

Ус хангамжийн эх үүсвэр

-  Эрүүл ахуйн хориглолтын бүс
-  Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс
-  Тэжээгдлийн муж

Орон нутгийн усны хамгаалалтын бүс

-  Орон нутгийн усны хамгаалалтын бүс

Масштаб 1:28960





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 7/150.

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн Т/20-08-06 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-002392 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Шижиргоулд ХХК-ийн Хошуу уул нэртэй алтны шороон ордын С-5, С-7 блокуудыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (тодотгол)-ийг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т зөвшөөрсүгэй.

3. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

5. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-002392 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хошуу уул нэртэй алтны шороон ордын С-5, С-7 блокуудыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (тодотгол)-ийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг Шижиргоулд ХХК-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

53701278



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2020 оны 08 сарын 30 өдөр

Дугаар Т/20-08-06

Улаанбаатар хот

Төв аймгийн Сэргэлэн сумын
нутагт орших MV-002392 тоот
ашиглалтын тусгай
зөвшөөрөлтэй, Хошуу уулын алтны
шороон ордын С-5, С-7 блокуудыг
ил аргаар ашиглах техник-эдийн
засгийн үндэслэлийн тодотголыг
хэлэлцсэн тухай

“Шижиргоулд” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Цариг ресурс” ХХК-ийн боловсруулсан Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-002392 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Хошуу уулын алтны шороон ордын С-5, С-7 блокуудыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд Монгол улсын зөвлөх инженер Л.Жаргалсайхан зөвлөж, Монгол улсын мэргэшсэн инженер Ч.Болдбаатар шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь Төслийн эдийн засгийн гол үзүүлэлтүүд, Ерөнхий мэдээлэл, Ордын геологийн судалгаа, Ил уурхайн хэмжээсүүд, үйлдвэрлэлийн нөөц, Олборлолт, Уурхайн угаан баяжуулалтын хэсэг, Хүний нөөц, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчин, Уурхайн үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө, Төслийн эдийн засаг зэрэг 11 бүлэг, Дүгнэлт, Хавсралт материал бүхий 113 хуудас тайлбар бичиг, 10 хавсралт зургаас бүрдэж байна.

2. MV-002392 тоот тусгай зөвшөөрлийн талбайд орших Хошуу уулын алтны шороон ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2000 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хурлын 56 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМХЭГ-ын даргын 2000 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 103 дугаар тушаалаар ордын нөөц нь химийн цэврээр бодитой В зэргээр 67.11 кг, боломжтой (С) зэргээр 208.58 кг бөгөөд нийт (В+С) зэргээр 275.58 кг алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

3. Ордын нөөцийг тооцохдоо талбайн үлдэгдэл хэсэг болох С-5, С-7 блокуудад нөөцийг тооцсон байна. Хошуу уулын алтны шороон ордын С-5, С-7 блокуудын олборлолтын нөөцийг тооцохдоо 2018 оны ашиглалтын үйл ажиллагааны тайланд үндэслэн боломжтой С зэргээр 44.04 мян.м³ элс, шлихээр 58.05 кг алт, химийн цэврээр 50.5 кг алтны нөөцтэй гэж тооцжээ.

00002714

4. Төслийн тодотголд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо олборлолтын явцад хаягдал үүсэхгүй, зөвхөн бохирдол үүсгэн олборлохоор тооцсон байна. Ашиглалтын үеийн бохирдол 17.31%-иар (7.62 мян.м³) тооцсон ба ордыг 2 улирлын хугацаанд ашиглах ба энэ хугацаанд 22.05 мян.м³ хөрс хуулж, магадласан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 58.05 кг шлихийн алт олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал 52.0 мян.м³ элс бөгөөд хөрс хуулалтын дундаж коэффициент 0.43 м³/м³. 2 дахь жилд нөхөн сэргээлт хаалтын ажил гүйцэтгэгдэхээр төлөвлөв.

5. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, эдийн засгийн үр ашиг зэргийг харгалзан үзэж ил аргаар авто тээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

6. Тус уурхайд Doosan LC-520 маркийн экскаватор – 1 ширхэг, 20 тн даацтай Howo ZZ3257N3247B маркийн автосамосвал - 4 ширхэг, Liebherr 734 маркийн бульдозер - 1 ширхэг, Doosan SD-300 маркийн утгуурт ачигч - 2 ширхэг гэсэн үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар ТЭЗҮ-ийн тодотголд тусгажээ.

7. Ордын технологи туршилтыг “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын Технологи туршилтын лабораторид хийлгэсэн бөгөөд гравитацийн аргаар баяжуулж, 94.3 хувийн металл авалттайгаар төслийн нийт хугацаанд химийн цэврээр 47.63 кг алт үйлдвэрлэнэ.

8. Олборлолтын явцад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг MNS5915:2008, MNS5916:2008, MNS5918:2008, MNS5850:2008 зэрэг Монгол улсын стандарт зааварчилгааны дагуу гүйцэтгэж, уулын ажлаар техникийн нөхөн сэргээлт хийж байгаа ба тухайн бүсийн уур амьсгалын нөхцөл байдалд тохирсон өвс, бутлаг ургамлаар биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр зардлыг төсөлд тусгасан байна.

9. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 137.0 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 1.53 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 97.53 сая төгрөг, төслийн хаалтын зардалд 31.41 сая төгрөг, хаалтын дараах хяналтын зардалд 6.52 сая төгрөгийг тус тус зарцуулахаар тусгажээ.

10. Төсөлд оруулсан хөрөнгө оруулалтын дүн төсөл боловсруулах үеийн байдлаар 427.48 сая төгрөг байгаа ба 1 гр алтыг 137,704.72 төгрөгөөр борлуулахаар тооцон төслийн нийт хугацаанд 6.56 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 1.45 тэрбум төгрөгийн зардал гарган, 4.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигт олж, хөрөнгө оруулалтаа 1 сарын хугацаанд нөхөхөөр тооцжээ. 1 гр алтны нэгжийн өртөг 30,358 төг байхаар тооцжээ.

11. Төсөл хэрэгжсэнээр улс, орон нутгийн төсөвт 1.03 тэрбум төгрөгийг татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлэх ба 28 ажлын байр бий болох бөгөөд төслийн хугацаанд нийт 4.72 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болно. 8 хувийн хорогдуулалтын норм тооцсон төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ 3.94 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 120% гарсан нь төслийн тодотгол эдийн засгийн хувьд үр ашигтайгаар хэрэгжих боломжтой гэж үзжээ.

12. Төсөл хэрэгжүүлэгчид, УУХҮЯ-ны сайд, БОАЖЯ-ны сайдын 2019 оны А/181, А/458 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдэрийг нөхөн сэргээлт, хаалтын журам”-ыг батлуулан хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг журмын дагуу хийхийг ЭБМЗ-өөс даалгаж байна.

13. Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, ордыг ашиглах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

14. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

15. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн “Цариг ресурс” ХХК хариуцах, түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч Монгол улсын мэргэшсэн инженер Ч.Болдбаатар хариуцах.

16. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд ахин тодотгол хийлгэж, ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэй.

17. Захиалагч компани Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хүлээн авах тухай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарснаас хойш 5 хоногт багтаан Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга гаргасан шийдвэрээ түдгэлзүүлэх, цуцлах эрхтэйг анхааруулах нь зүйтэй.

Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-002392 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Хошуу уулын алтны шороон ордын С-5, С-7 блокуудыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хүлээн авах шийдвэр гаргахыг уламжлахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.МӨНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.БОЛД-ЭРДЭНЭ

Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших "Хошуу уул"-ын алтны ш

Блокын дугаар, Нөөцийн зэрэг	Геологийн нөөц (2000 он)								2000-2019 онд олборлосон			2020 оны эхэн дэх нөөц				
	Блокын талбай	Хөрсний зузаан	Элсний зузаан	Хөрс хуулалт	Элсний нөөц	Дундаж агуулга /шлих/	Металлын нөөц /шлих/	Металлын нөөц /хими/	Элсний нөөц	Дундаж агуулга /шлих/	Металлын нөөц /хими/	Хөрс хуулалт	Элсний нөөц	Дундаж агуулга /шлих/	Металлын нөөц /хими/	Блокын талбай
	мян.м ²	м	м	мян.м ³	мян.м ³	гр/м ³	кг	кг	мян.м ³	гр/м ³	кг	мян.м ³	мян.м ³	гр/м ³	кг	мян.м ²
В-1	20.95	1.30	1.20	27.24	25.14	1.036	26.05	22.66	25.14	1.036	22.66					
В-2	12.27	1.60	1.10	19.63	13.50	1.084	14.63	12.73	13.50	1.084	12.73					
В-3	10.02	1.40	1.40	14.03	14.03	0.832	11.67	10.15	14.03	0.832	10.15					
В-4	14.02	0.90	1.50	12.62	21.03	1.179	24.79	21.57	21.03	1.179	21.57					
С-1	6.23	1.20	0.60	7.48	3.74	0.264	0.99	0.86	3.74	0.264	0.86					
С-2	24.21	1.30	0.70	31.47	16.95	0.373	6.32	5.50	16.95	0.373	5.50					
С-3	22.79	1.10	0.80	25.07	18.23	0.444	8.10	7.04	18.23	0.444	7.04					
С-4	40.53	0.70	1.00	28.37	40.53	0.391	15.85	13.79	40.53	0.391	13.79					
С-5	51.34	0.70	1.20	35.94	61.61	0.447	27.54	23.96	36.55	0.45	1.76	14.62	25.06	1.018	22.20	20.88
С-6	50.06	0.70	1.20	35.04	60.07	0.582	34.96	30.42	60.07	0.58	30.42					
С-7	48.90	0.70	1.20	34.23	58.68	0.678	39.79	34.61	39.70	0.68	6.3	11.07	18.98	1.714	28.30	15.81
С-8	51.07	0.90	1.20	45.96	61.28	0.635	38.92	33.86	61.28	0.64	33.86					
Нийт	57.26	1.30	1.30	73.51	73.70	1.047	77.14	67.11	73.70	1.03	67.11					
Нийт	295.13	0.80	1.10	243.56	321.09	0.537	172.45	150.03	277.05	0.48	99.53	25.69	44.04	1.32	50.50	36.70
Нийт	352.39	0.90	1.10	317.08	394.79	0.632	249.59	217.15	350.75	0.662	166.6	25.69	44.04	1.32	50.50	36.70
С-9	14.52	1.2	1.2	17.42	17.42	1.007	17.55	15.26	17.42	1.01	15.26					
С-10	9.73	1.0	1.2	9.73	11.68	0.974	11.37	9.89	11.68	0.97	9.89					
С-11	10.00	1.10	1.00	11.00	10.00	1.565	15.65	13.62	10.00	1.57	13.62					
С-12	14.58	0.80	0.8	11.66	11.66	1.412	16.47	14.33	11.66	1.41	14.33					
С-13	13.56	0.50	0.6	6.78	8.14	0.582	4.74	4.12	8.14	0.58	4.12					
С-14	3.3	0.60	0.50	1.98	1.65	0.922	1.52	1.32	1.65	0.92	1.32					
Нийт	65.69	0.90	0.90	58.58	60.55	1.111	67.29	58.55	60.55	1.11	58.55					
Нийт	57.26	1.30	1.30	73.51	73.70	1.047	77.14	67.11	73.70	1.047	67.11					
Нийт	360.82	0.80	1.1	302.14	381.64	0.628	239.75	208.58	337.60	0.628	158.0	25.69	44.04	1.32	50.50	36.70
Нийт	418.08	0.90	1.10	375.65	455.34	0.696	316.89	275.69	411.30	0.696	225.1	25.69	44.04	1.32	50.50	36.70

Тус ордын 2018 оны ашиглалтын үйл ажиллагааны тайланд тулгуурлан ордыг ашиглах ТЭЗҮ-ийг б
 үйлдвэрлэлийн нөөцийг уул уурхайн сайдын 2015 оны 9-р сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын д
 Ордын үйлдвэрлэлийн нийт нөөц нь (В') 51.66 мян.м³ элс буюу хими цэврээр 50.50 кг алт
 "Хошуу уул" (Бэлхийн ам)-ын алтны шороон ордод хаягдалгүй ашиглалт явуулахын тулд алттай элсн
 цуг олборлолтонд хамруулахаар тооцсон. Мөн уурхайн хажуугаас элсийг бохирдуулахаар тооцсон бөгөө

УИЛААНБААТАР ХОТ
 ЦАРИГ РЕСУРС
 ХХК
 1172336 24.5308003

Үзүүлэлт гаргасан:
 "Цариг Ресурс" ХХК-ийн
 Уулын инженер: *[Signature]* /А.Эрдэнэбулган /

ЭБМЗ-ийн /20080808/ дүгээр дүгнэлтийн хавсралт

00он ордын C-5, C-7 блокуудын үйлдвэрлэлийн нөөцийн нэгдсэн хүснэгт

Ашиглалтын нөөц							Бохирдолт						Үйлдвэрлэлийн нөөц					
Хөрсний зузаан	Элсний зузаан	Хөрс хуулагт	Элсний нөөц	Дундаж агуулга /шлих/	Металлын нөөц /шлих/	Металлын нөөц /хими/	Бохирдолтын хувь	Хамгаалалтын цулын дээд доод нийлбэр зузаан	Ул, таазнаас нэмэгдэх чулуулгийн хэмжээ	Бортоор нэмэгдэх чулуулаг	Бохирдуулагч чулуулаг	Блолын дугаар, Нөөцийн зэрэг	Бортоор нэмэгдэх хөрс	Хөрс хуулагт	Элсний нөөц	Дундаж агуулга /шлих/	Металлын нөөц /шлих/	Металлын нөөц /хими/
м	м	мян.м ³	мян.м ³	гр/м ³	кг	кг	%	м	мян.м ³	мян.м ³	мян.м ³		мян.м ³	мян.м ³	мян.м ³	гр/м ³	кг	кг
70	1.20	14.62	25.06	1.018	25.52	22.20	17.26	0.20	4.18	0.15	4.33	B'-5	0.02	12.55	29.39	0.868	25.52	22.20
70	1.20	11.07	18.98	1.714	32.53	28.30	17.37	0.20	3.16	0.13	3.30	B'-7	0.02	9.50	22.27	1.460	32.53	28.30
70	1.20	25.69	44.04	1.32	58.05	50.50	17.31	0.20	7.34	0.28	7.62		0.04	22.05	51.66	1.12	58.05	50.50
70	1.20	25.69	44.04	1.32	58.05	50.50	17.31	0.20	7.34	0.28	7.62		0.04	22.05	51.66	1.12	58.05	50.50
70	1.20	25.69	44.04	1.32	58.05	50.50	17.31	0.20	7.34	0.28	7.62		0.04	22.05	51.66	1.12	58.05	50.50
70	1.20	25.69	44.04	1.32	58.05	50.50	17.31	0.20	7.34	0.28	7.62		0.04	22.05	51.66	1.12	58.05	50.50

ловсруулсан бөгөөд уурхайн хил хязгаар дотор орших бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай туу боломжтой (C) зэргийн нөөцийг магадласан (B') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв.

болж байна. /Шлихээр 58.05 кг/

й давхаргаас дээш орших хучаас хөрсөнд 0.1 м зузаан үе үлдээх, ул чулуулгаас мөн 0.1 м зузаан үеийг элстэй д эдгээр үеүд бохирдуулагч чулуулаг болно. Иймээс ордыг ашиглалтын үед хаягдалгүй олборлоно.

Танилцсан:

АМГТГ-ын ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, бүртгэл

хариуцсан мэргэжилтэн: *Д.Зол* / Ц.Золзаяа /

13/07 2020

ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ж. ДАШ-ЯЙЧИЛ

**2022 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ,
НӨХӨН СЭРГЭЭХ ГЭРЭЭ**

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 22/01

Зуунмод сум
НЮА00489067932

Үндэслэл: Байгаль орчныг хамгаалах, ашигт малтмалын орддыг уламжлалт болон орчин үеийн дэвшилтэт технологиор байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй, иж бүрэн ашиглуулах, Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас тусгай эрх олгогдсон мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй ажиллуулах, уулын ажлын төлөвлөгөөний дагуу хөндөгдсөн газрын хэвлий, талхлагдсан хөрсийг нөхөн сэргээлгэх, доройтлоос хамгаалахад оршино.

ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ:

1. “Шижир гоулд” ХХК нь Ашигт малтмал, газрын тосны газар, Геологи уул уурхайн кадастрын хэлтсээс олгосон ашигт малтмалын орд газрыг ашиглах MV-002392 тоот хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй.
2. Уул уурхайн олборлох үйлдвэрлэлийг 2022 оны батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу MV-002392 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн С-5, С-7 блокуудад олборлолт явуулж 46,9 мян.м³ хүдэр олборлохоор төлөвлөсөн байна.
3. “Шижир гоулд” ХХК нь өөрийн эзэмшилд байгаа Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Хошуу уул ордод хамаарагдах MV-002392 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд 9-гаад техникийн нөхөн сэргээлт, 2 га талбайд биологийн нөхөн сэргээлт дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн хүрээнд 3,5га талбайд нөхөн сэргээлт хийж 5000 ширхэг мод тарих

3.5 га	107 14 52.30	47 28 42.50
	107 14 51.10	47 28 42.80
	107 14 57.69	47 29 02.00
	107 14 56.81	47 29 12.47
	107 14 57.40	47 29 12.57
	107 14 58.80	47 29 06.40
	107 14 59.40	47 28 58.30

2022 оны 10-р сард Төв аймгийн нөхөн сэргээлтийг хүлээн авах мэргэжлийн комисс болон Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгнө.

4. “Шижир гоулд” ХХК нь Монгол улсын “Ашигт малтмалын тухай хууль”-ийн дөрөвдүгээр бүлгийн 39 дүгээр зүйлийн 1,9 дэх заалтын дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх баталгаа болгон тухайн жилд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын 50%-тай тэнцэх 8.0 сая төгрөгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас нээсэн “100900013406” тоот тусгай дансанд төвлөрүүлсэн.
5. Олборлолтын улирлын эцэст тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй нөхцөлд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажилд зарцуулах бөгөөд хүрэлцэхгүй нөхцөлд лиценз эзэмшигч компаниас хөрөнгө нэмж гаргуулна. Энэ нөхцөлд ашиглагч байгууллага байгаль орчныг нөхөн сэргээх үүргээсээ хуулийн дагуу чөлөөлөгдөхгүй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх
Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын Газар, газрын хэвлий түүний
баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт
хариуцсан мэргэжилтэн

С.ЭРДЭНЭЦОГТ

Харилцах утас: 88044188

Төв аймгийн МХГ-ын Байгаль орчны
хяналтын улсын байцаагч

“Шижир гоулд” ХХК -ний

Захирал

У.Уянга /Ж.Уянга/

Харилцах утас: /99042536

Харилцах утас:



УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/114

Сүмбэр сум

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын "Усны тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг "Усны газар"-ын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 97 тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. "Шижиргоулд" ХХК-ийн унд, ахуйн хэрэгцээнд 882.0 шоометр, ашигт малтмал баяжуулахад 53'760 шоометр, зам талбайн усалгаанд 864 шоометр, биологийн нөхөн сэргээлтэд 14'626.8 шоометр, "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд мод тарихад 54 шоометр нийт 69'304 шоометр усыг 1 жилийн хугацаагаар "Шижиргоулд" ХХК-д ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. "Шижиргоулд" ХХК-ийн ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Газар зүйн мэдээллийн систем, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн /О.Батхүү/-д үүрэг болгосугай.

3. Монгол Улсын "Улсын тэмдэгтийн хураамжийн тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.20-д заасны дагуу ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Төв аймгийн Төрийн сан банкны дансанд тушаах, "Төсвийн тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг нийслэлийн төсөвт гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэхийг "Шижиргоулд" ХХК-ийн захирал /Ж.Уянга/-д үүрэг болгосугай.

4. "Усны тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтын дагуу ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны ашиглах боломжит нөөцийн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхгүй байх болон "Усны тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2022 оны 12-р сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг "Шижиргоулд" ХХК-ийн захирал /Ж.Уянга/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.САРАНТУЯА

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГА /Л.ТӨМӨРЧӨДӨР/

Хог хаягдлын гэрээ

2022 оны 02-р сарын 16 өдөр

Дугаар 11

Гэрээний зорилго:

Монгол Улсын “Хог хаягдлын тухай” хуулийг хэрэгжүүлж хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах зорилготой.

Гэрээний эрх зүйн үндэслэл:

- Монгол Улсын хог хаягдлын тухай хууль
- Монгол Улсын Ариун цэврийн тухай хууль

Гэрээ байгуулагч талууд:

Нэг талаас Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГазрыг төлөөлж Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Дэлгэрсүрэн нөгөө талаас “Ноён тохой трейд” ХХК тохиролцож 2022 оны 02-р сарын 16-аас 2023 оны 02-р сарын 16-ийг хүртэлх 1 жилийн /нэг/ хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ААНэгж, байгууллагын эрх, үүрэг

1.1. Монгол Улсын “Хог хаягдлын тухай” хуулийн 10-р зүйлийн заалт, Сэргэлэн сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 62 тоот тогтоолыг үндэслэн хог хаягдал гаргасаны төлбөрт сар бүр 30000 /гучин мянга/ төгрөг буюу жилд 360 000 /гурван зуун жаран мянган / төгрөгийг /Төрийн сан банк/ шилжүүлж байна.

1.2. ААНэгж, байгууллага өөрийн ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэх, тээвэрлэх, хог хаягдлын талаархи дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байх.

1.3. ААНэгж, байгууллага үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ түүний тухай мэдээллийг сумын ЗДТГазарт үнэн зөв мэдээлж байх.

1.4. Хог хаягдлын ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтандаа эзэмшүүлж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.

ХОЁР. Сумын ЗДТГазрын эрх үүрэг

- 2.1. Монгол Улсын "Хог хаягдлын тухай" хуулийн 10-р зүйлийг үндэслэн ААНэгж, байгууллагаас хог хаягдал гаргасан төлбөр нэхэмжилж авна.
- 2.2. Хуулиар олгосон эрхийн дагуу ААНэгж, байгууллага өөрийн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээний талаар өгч буй мэдээлэл, орчны ариун цэврийн байдалд хяналт тавьж, шаардлага тавих эрхтэй.
- 2.3. Хог хаягдлыг ил асгах, орчин тойрныг бохирдуулах, ариун цэврийн шаардлага хангаагүй нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол "Зөрчлийн тухай" хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ГУРАВ. БУСАД

Монгол Улсын "Хог хаягдлын тухай" хууль, сумын ИТХ-ын тогтоолд өөрчлөлт орсон тохиолдолд төлбөрийн хэмжээг харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

Гэрээ байгуулсан:

Төв аймаг Сэргэлэн сумын
Байгаль орчны хяналтын улсын
байцаагч
..... /Г.Дэлгэрсүрэн/
Утас: 99208676,92067989



овогтой
/гарын үсэг/

Утас: 88115786

558-5p хогоо 14-1-8



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГАА

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3599,
И-мэйл: umardgobi14@gmail.com, Вэбсайт: www.gobiwater.mn

2022.05.19 № 105
танай _____-ны № _____-т

“ШИЖИРГОУЛД” ХХК-Д

Монгол улсын “Усны тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7, 29.1 дэхь заалт, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-ын 2022 оны 05 дугаар сарын 17-ний өдрийн 77 тоот ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн “Шижиргоулд” ХХК-д 2022 оны ус ашиглах зөвшөөрөл олгож, гэрээг байгуулан хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Төв аймгийн Татварын хэлтэс,
Байгаль орчин, аялал жуулчлалын газарт
Хавсралт хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.САРАНТУЯА



БАТЛАВ.

УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

...../Б.САРАНТУЯА/



БАТЛАВ.

“ШИЖИР ГОУЛД” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

...../Ж.УЯНГА/



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 05-р сарын 19-ний өдөр

Дугаар-14

Чойр хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын “Усны тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-ын гаргасан 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 97 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны олгосон 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

